ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БУА-2021/135/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Булган аймаг
2021 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр
Утас:90900910 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 99057478 Цахим хаяг:Enhtsoodolj@audit.gov.mn
Аудитор: Д.Даариймаа
Утас:88555089 Цахим хаяг: daariimaado@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Contents


2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .......... 5

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .......... 5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .......... 6

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .......... 8

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .......... 10

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .......... 10

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .......... 12

3.Аудитын тайлан .......... 14

3.1. Ерөнхий зүйл .......... 14

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .......... 14

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .......... 14

3.4. Материаллаг байдал .......... 14

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .......... 15

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .......... 16

3.7. Шилэн дансны мэдээлэл .......... 17

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .......... 17

3.9. Аудитын илрүүлэлт .......... 17

Залруулсан алдаа .......... 18

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .......... 18

Аудитын зөвлөмж .......... 18

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .......... 18

4. Менежментийн захидал .......... 18

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .......... 22

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2021.02.25 № 67

танай ______________-ны №__________________т

ОРХОН СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ч.ЦАГААНХҮҮ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. *Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

006020142

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **53,902,021.26** | **43,222,974.93** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 49,502,521.26 | 43,222,974.93 |
| **351** | **Түүхий эд материал** | 11,651,657.39 | 944,941.06 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 11,651,657.39 | 944,941.06 |
| **354** | **Хангамжийн материал** | 24,246,440.82 | 28,673,610.82 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 764,700.00 | 786,700.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,319,640.00 | 5,075,590.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 1,300,000.00 | 1,580,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,005,280.00 | 2,000,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,873,200.00 | 1,247,700.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 17,983,620.82 | 17,983,620.82 |
| 35600 | Мал амьтад | 13,604,423.05 | 13,604,423.05 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,428,727,821.89** | **1,669,088,570.48** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,428,727,821.89 | 1,669,088,570.48 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,366,285,805.39 | 1,606,297,820.67 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 840,342,389.10 | 1,369,247,778.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (49,565,849.58) | (209,813,570.91) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 224,513,015.00 | 212,799,685.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (111,033,025.35) | (115,493,646.23) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 61,722,503.85 | 93,755,120.49 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (42,324,207.04) | (17,448,963.09) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 79,451,494.11 | 52,433,434.74 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (48,411,282.51) | (19,511,389.67) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 370,362,079.72 | 87,947,832.82 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (135,196,846.91) | (24,043,995.48) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 174,503,575.00 | 174,503,575.00 |
| 39217 | Ном | 1,921,960.00 | 1,921,960.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 62,442,016.50 | 62,790,749.81 |
| 39301 | Програм хангамж | 1,745,000.00 | 1,745,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,726,250.19) | (1,726,250.19) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 62,772,000.00 | 62,772,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,482,629,843.15** | **1,712,311,545.41** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **110,040.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 110,040.00 |
| **413** | **Өглөг** | - | 110,040.00 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 110,040.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 110,040.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,172,067,371.50** | **1,401,639,033.76** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,172,067,371.50 | 1,401,639,033.76 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 653,158,312.96 | 882,729,975.22 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 653,158,312.96 | 653,507,046.27 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 229,222,928.95 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 518,909,058.54 | 518,909,058.54 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,172,067,371.50** | **1,401,749,073.76** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **715,631,273.00** | **680,721,972.12** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **15,260,340.00** | **26,145,565.12** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 15,260,340.00 | 26,145,565.12 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 15,260,340.00 | 26,145,565.12 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 967,440.00 | 1,500,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 14,292,900.00 | 24,645,565.12 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **700,370,933.00** | **654,576,407.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 350,544,167.00 | 229,393,507.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 10,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 350,544,167.00 | 219,393,507.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 349,826,766.00 | 425,182,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 349,826,766.00 | 425,182,900.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **463,258,346.17** | **538,819,230.31** |

| | | | |
|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **463,258,346.17** | **538,819,230.31** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 448,349,867.17 | 535,949,425.31 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 206,290,265.00 | 244,159,377.43 |
| 210101 | Үндсэн цалин | 169,261,002.00 | 194,651,317.00 |
| 210102 | Нэмэгдэл | 30,022,897.00 | 38,191,135.73 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 7,006,366.00 | 11,316,924.70 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 25,980,600.00 | 29,120,315.57 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,585,392.23 | 20,534,509.86 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,019,377.44 | 2,417,059.98 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,615,501.97 | 1,923,567.99 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 340,428.16 | 385,161.62 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,419,900.20 | 3,860,016.12 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 51,029,100.00 | 88,608,700.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,771,700.00 | 6,181,300.00 |
| 210302 | Түлш, халаалт | 47,257,400.00 | 82,427,400.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 20,862,597.00 | 23,387,309.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,159,548.00 | 2,604,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,624,549.00 | 18,879,937.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,078,500.00 | 1,903,072.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 696,300.00 | 1,288,950.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 696,300.00 | 1,288,950.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 15,335,080.61 | 3,710,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 15,335,080.61 | 3,710,800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,144,000.00 | 3,110,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,144,000.00 | 3,110,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 8,418,380.00 | 6,894,280.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,577,262.00 | 5,940,980.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 108,000.00 | 216,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 306,280.00 | 296,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 305,838.00 | 320,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 121,000.00 | 121,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 112,593,544.56 | 135,669,693.31 |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 69,008,111.00 | 54,661,793.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,200,000.00 | 164,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 39,385,433.56 | 80,843,900.31 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 14,908,479.00 | 2,869,805.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 800,879.00 | 2,869,805.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 800,879.00 | 2,869,805.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **252,372,926.83** | **141,902,741.81** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 14,985,778.00 | 25,810,677.53 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 9,777,778.00 | 2,310,677.53 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 5,208,000.00 | 23,500,000.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (14,985,778.00) | (25,810,677.53) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **237,387,148.83** | **116,092,064.28** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **701,338,373.00** | **656,076,407.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **967,440.00** | **1,500,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 967,440.00 | 1,500,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 967,440.00 | 1,500,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 967,440.00 | 1,500,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **700,370,933.00** | **654,576,407.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 350,544,167.00 | 229,393,507.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 10,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 350,544,167.00 | 219,393,507.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 349,826,766.00 | 425,182,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 349,826,766.00 | 425,182,900.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **417,116,896.00** | **460,107,460.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **417,116,896.00** | **460,107,460.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **402,208,417.00** | **457,237,655.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 206,290,265.00 | 243,082,253.00 |
| 210101 | Үндсэн цалин | 151,112,697.00 | 166,773,801.00 |
| 210102 | Нэмэгдэл | 31,253,174.00 | 47,986,199.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 23,924,394.00 | 28,322,253.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 25,980,600.00 | 30,317,800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,666,600.00 | 20,588,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,078,500.00 | 2,432,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,662,800.00 | 1,945,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 415,700.00 | 486,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,157,000.00 | 4,864,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 50,758,700.00 | 88,438,700.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,501,300.00 | 6,181,300.00 |
| 210302 | Түлш, халаалт | 47,257,400.00 | 82,257,400.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 18,729,200.00 | 19,045,842.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,688,900.00 | 2,646,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,961,800.00 | 14,496,470.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,078,500.00 | 1,903,072.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 800,000.00 | 1,000,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 800,000.00 | 1,000,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,100,852.00 | 4,471,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,650,852.00 | 4,471,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,144,000.00 | 3,110,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,144,000.00 | 3,110,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 7,893,759.00 | 7,792,689.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,052,641.00 | 6,839,389.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 108,000.00 | 216,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 306,280.00 | 296,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 305,838.00 | 320,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 121,000.00 | 121,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 78,511,041.00 | 59,978,871.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 74,311,041.00 | 59,784,871.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,200,000.00 | 194,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **14,908,479.00** | **2,869,805.00** |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 800,879.00 | 2,869,805.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 800,879.00 | 2,869,805.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **284,221,477.00** | **195,968,947.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **285,671,477.00** | **195,968,947.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **285,671,477.00** | **195,968,947.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 285,671,477.00 | 195,968,947.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 285,671,477.00 | 195,968,947.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(285,671,477.00)** | **(195,968,947.00)** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 310,562,471.65 | 518,909,058.54 | 414,153,300.13 | 1,243,624,830.32 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 1,617,864.00 | 1,617,864.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **310,562,471.65** | **518,909,058.54** | **415,771,164.13** | 1,245,242,694.32 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 237,387,148.83 | 237,387,148.83 |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **310,562,471.65** | **518,909,058.54** | **653,158,312.96** | 1,482,629,843.15 |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **310,562,471.65** | **518,909,058.54** | **653,158,312.96** | 1,482,629,843.15 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 348,733.31 | 348,733.31 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **310,562,471.65** | **518,909,058.54** | **653,507,046.27** | 1,482,978,576.46 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 229,222,928.95 | 229,222,928.95 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **310,562,471.65** | **518,909,058.54** | **882,729,975.22** | 1,712,201,505.41 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 660854377.00 | 701987494.00 | 426132900.00 | 423822995.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 375182900.00 | 416316017.00 | 426132900.00 | 422722995.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 361075300.00 | 402208417.00 | 426132900.00 | 422722995.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 207847900.00 | 206290265.00 | 243235800.00 | 243082253.00 |
| 210101 | Үндсэн цалин | 151176100.00 | 151112697.00 | 166793100.00 | 166773801.00 |
| 210102 | Нэмэгдэл | 32386300.00 | 31253174.00 | 47966900.00 | 47986199.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 24285500.00 | 23924394.00 | 28475800.00 | 28322253.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 25980600.00 | 25980600.00 | 30353800.00 | 30317800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17666600.00 | 17666600.00 | 20624200.00 | 20588200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2078500.00 | 2078500.00 | 2432400.00 | 2432400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1662800.00 | 1662800.00 | 1945900.00 | 1945900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 415700.00 | 415700.00 | 486500.00 | 486500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4157000.00 | 4157000.00 | 4864800.00 | 4864800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 50758700.00 | 50758700.00 | 88438700.00 | 88438700.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3501300.00 | 3501300.00 | 6181300.00 | 6181300.00 |
| 210302 | Түлш, халаалт | 47257400.00 | 47257400.00 | 82257400.00 | 82257400.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 18903500.00 | 18729200.00 | 19256100.00 | 19045842.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2688900.00 | 2688900.00 | 2646300.00 | 2646300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13961800.00 | 13961800.00 | 14607800.00 | 14496470.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,252,800.00 | 2,078,500.00 | 2,002,000.00 | 1,903,072.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 800,000.00 | 800,000.00 | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 800,000.00 | 800,000.00 | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,209,300.00 | 6,100,852.00 | 5,571,500.00 | 4,471,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,759,300.00 | 4,650,852.00 | 4,471,500.00 | 4,471,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 9,010,500.00 | 7,144,000.00 | 3,415,700.00 | 3,110,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,010,500.00 | 7,144,000.00 | 3,415,700.00 | 3,110,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 9,906,300.00 | 7,893,759.00 | 5,161,300.00 | 3,562,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,725,300.00 | 7,052,641.00 | 4,100,000.00 | 2,609,600.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 120,000.00 | 108,000.00 | 324,000.00 | 216,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 530,000.00 | 306,280.00 | 296,300.00 | 296,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 410,000.00 | 305,838.00 | 320,000.00 | 320,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 121,000.00 | 121,000.00 | 121,000.00 | 121,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 31,658,500.00 | 78,511,041.00 | 29,700,000.00 | 29,694,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 27,458,500.00 | 74,311,041.00 | 29,500,000.00 | 29,500,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,200,000.00 | 4,200,000.00 | 200,000.00 | 194,000.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **285,671,477.00** | **285,671,477.00** | **-** | **1,100,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 285,671,477.00 | 285,671,477.00 | - | 1,100,000.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 285,671,477.00 | 285,671,477.00 | - | 1,100,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 375,183,100.00 | 350,794,206.00 | 393,854,300.00 | 426,682,900.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 361,833,100.00 | 349,826,766.00 | 393,854,300.00 | 425,182,900.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 361,833,100.00 | 349,826,766.00 | 393,854,300.00 | 425,182,900.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 13,350,000.00 | 967,440.00 | - | 1,500,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 967,440.00 | - | 1,500,000.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **282,930,477.00** | **229,383,607.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **-** | **34,514,660.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | 34,514,660.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 4,229,789.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 4,229,789.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | 30,284,871.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 30,284,871.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **-** | **9,900.00** |
| 213503 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | - | 9,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **282,930,477.00** | **194,868,947.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 282,930,477.00 | 194,868,947.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 282,930,477.00 | 194,868,947.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 350,544,167.00 | 229,393,507.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 350,544,167.00 | 229,393,507.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 342,886,377.00 | 10,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 7,657,790.00 | 219,393,507.00 |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Орхон сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Засаг даргын тамгын газрын дарга Ч.Цагаанхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, биет бус хөрөнгийг зөв бүртгэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 15-наас 2021 оны 02 дугаар сарын 24–ний хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Содном, аудитор Д.Даариймаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Орхон сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Сумын Засаг даргын тамгын газрын зорилт нь сумын Засаг даргаас Засаг захиргаа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд эдийн засаг нийгмийг хөгжүүлэх, стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамж, зохицуулалт хийх, мониторингийн хяналт тавих, үнэлж дүгнэх, нутгийн удирдлагын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, мэргэжлийн удирдлагаар хангах замаар иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд мэргэжлийн зөвлөгөө дэмжлэг үзүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Орхон сумын Засаг даргын тамгын газар нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайлант онд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг

сонгож, эрсдэлийн түвшинг “10607.6 мянган төгрөг” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн тайлангийн нийт зардлын 254992.6 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 5099.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд хувийг өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Орхон сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 229332.9 мянган төгрөгөөр буюу 15.5хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 0 | 0 |
| Авлага | 0 | 0 | 0 |
| Урьдчилгаа | 0 | 0 | 0 |
| Бараа материал | 53902.0 | 43222.9 | -10679.1 |
| Үндсэн хөрөнгө | 1428727.8 | 1668739.8 | 240012.0 |
| **Нийт хөрөнгө** | 1482629.8 | 1711962.8 | 229332.9 |
| Өр төлбөр | | 110.0 | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1482629.8 | 1711852.7 | 229222.9 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1482629.8 | 1711962.8 | 229332.9 |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэлгүй тайлагнажээ.

Авлага дансны үлдэгдэлгүй тайлагнажээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 43222.9 мянган төгрөг болж 10679.1 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 39370.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, иргэд, аж ахуйн нэгжийн хандив 5035.4 мянган төгрөг, шинэ хөдөөр хөтөлбөрөөс 4543.3 мянган төгрөгийн зохиомол хээлтүүлгийн багаж, сумын ОНХС-гаас 1000.0 мал эмнэлгийн хувцас тоног төхөөрөмж үнэ төлбөргүй орлогодож, 45044.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, шинэ хөдөө төсөлд 16250.0 мянган төгрөгийн чацарганы суулгац үнэ төлбөргүй шилжүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1668739.8 мянган төгрөг болж 240012.0 мянган төгрөгөөр өссөн нь барилга байгууламжийн дансанд өмнөх онд спорт заалыг шилжүүлсэн төлбөрийн дүнгээр 222930.5 мянган төгрөгөөр тайланд тусгасныг залруулж тайлант онд 440288.1 мянган төгрөгөөр орлогодож тайлагнаснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь хөрөнгө оруулалтаар 440288.1, урсгал төсвийн худалдан авалтаар 1100.0, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн мянган төгрөгийн 363086.1, дахин үнэлгээний нэмэгдэл 24645.5 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 283022.7, акталсан 33573.9, бусад 272730.7 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 110.0 мянган төгрөг болж 110.0 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагад төлөх өглөгийг барагдуулаагүйгээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1711852.7 мянган төгрөг болж 229222.9 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгийн нэмэгдлээс шалтгаалжээ.

Орхон сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 60221.6 мянган төгрөгөөр буюу 8.4 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 4 орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 57560.9 мянган төгрөгөөр буюу 12.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, гэрэл цахилгаа, түлш халаалт, урсгал засвар, дотоод албан томилолт, бараа үйлчилгээний бусад зардал, үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардлууд байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 389694.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 389694.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 26438.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 426132.9 мянган төгрөгөөр баталсан байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 426132.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 424632.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 1500.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 425182.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 1500.0 мянган төгрөг нийт 426682.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 423823.0 мянган төгрөгийг зарцуулж 2859.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 423823.0 мянган төгрөг буюу 99.3 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 153.5, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 36.0, тээвэр шатахууны зардлыг 111.3, шуудан холбоо интернетийн зардлыг 98.9, дотоод албан томилолтын зардлыг 305.7, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 1490.4, аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардлыг 108.0, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 6.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны зардал арга хэмжээ 617.8 мянган төгрөгөөр, баг, хорооны үйл ажиллагааны зардал арга хэмжээ 1922.0, хөтөлбөр

төслийн дотоод урсгал 320.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн статистикийн хэлтсээс хүн ам орон сууцны тооллого явуулах болон хяналт хийх зардалд 3365.5, малын ашиг шимийн судалгаанд 556.6, хагас жилийн мал тооллогод 864.3, НҮТС-н судалгаанд 50.0, аймгийн ОНХС-гаас спорт заалны санхүүжилт 184311.1 төгрөг, аймгийн ХХААГ-аас үлийн цагаан оготно устгалд 10080.0, аймгийн БХС-гаас морин эргүүл хийх зардалд 1728.0, Сумын төвийн хогийн цэг дарж булах ажилд 24937.9, хог цэвэрлэх зардалд 3000.0, аймгийн ГБХЗХГ-аас ковид-19-тэй холбоотой эмзэг бүлгийн айлуудад хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэхэд 500.0 нийт 229393.5 мянган төгрөгийн санхүүжилтээс малын ашиг шимийн судалгаанаас 9.9 мянган төгрөгийн гүйлгээ буцаагдаж оны эцэст төвлөрүүлсэн байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 151 мэдээлэл байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1456.5 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн актын төлбөрийг төлж. Аудитаар өгсөн 8095.9 мянган төгрөгийн 4 зөвлөмжийн хэрэгжилт 75 хувьтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 1456.5 | 1 | 1456.5 | | | |
| Албан шаардлага | | | | | | | |
| Зөвлөмж | 4 | 8095.9 | 4 | 8095.9 | | | |
| Нийт дүн | 5 | 9552.4 | | 9552.4 | | | |

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 311304.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 306479.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 298.6 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 4526.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

**Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Спорт заалыг өмнөх онд орлогоор буруу тусгасныг 245419.2 мянган төгрөгийн залруулга хийгдсэн.
2. Хандиваар ирсэн хөрөнгийг 19664.7 мянган төгрөгөөр илүү орлогодсоныг залруулсан.
3. Шилжүүлсэн 16500.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас тайлагнасныг залруулж, үнэ төлбөргүй гарсан зардалд бүртгэж залруулга хийсэн
4. Хөрөнгийн дахин үнэлгээний 24645.6 мянган төгрөгийг бичилтийг залруулсан.
5. Үнэ төлбөргүй ирсэн 500.0 мянган төгрөгийг шатахууныг орлогодоогүйг орлогодож залруулсан.

**Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 4825.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 298.6 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Албан томилолтын зардлыг илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:
Анхан шатны баримтгүй нярвын дансанд шилжүүлсэн 148.6 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоох.

2. Нэхэмжлэх зарлагын баримтгүй 148.6 мянган төгрөгийг нярвын дансанд шилжүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:
Анхан шатны баримтгүй нярвын дансанд шилжүүлсэн 148.6 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоох.

**Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 4526.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Даргаагийн аудитаар Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг анхааралдаа авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*1. Зардлын данстай холбоотой асуудал*

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

Нярвын тайланд 150.0 мянган төгрөгийн бараа материал орлого, зарлагын баримтгүй, 1120.5 мянган төгрөгийн бараа материал шаардахгүй зарцуулсан, 143.0 мянган төгрөгийн засварын хөлс орлогодсон, харилцахын нэхэмжлэх бараа материалын орлого зарлага зөрүүтэй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дэх заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

*1.2. <u>Эрсдэл:</u>*

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

1.3. *<u>Өгсөн зөвлөмж</u>:*

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дэх заалтыг мөрдөж ажиллах.

*1.4. <u>Байгууллагаас өгсөн хариу тайлбар:</u>*

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг хүлээн зөвшөөрсөн.

*2.Дотоод хяналттай холбоотой асуудал*

*<u>2.1. Илрүүлэлт:</u>*

Нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас цэвэрлэгээний материал худалдан авахаар төлөвлөн зарцуулдаг нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалтыг зөрчсөн байна.

*<u>2.2. Эрсдэл</u>:*

Төсвийн тухай хууль хэрэгжихгүй байх.

*<u>2.3. Өгсөн зөвлөмж</u>:*

Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"-ын дагуу төсвийн зардлын төрлийг төлөвлөж зарцуулах.

*<u>2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:</u>*

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг хүлээн зөвшөөрсөн.

*3.Засаг даргын нөөц хөрөнгөтэй холбоотой асуудал.*

*<u>3.1. Илрүүлэлт:</u>*

Засаг даргын захирамжаар зарцуулах мөнгөн дүнгээс 256.2 мянган төгрөг илүү зарцуулсан нь 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 3.1 дэх заалтыг зөрчсөн байна.

*<u>3.2. Эрсдэл</u>:*

Төсвийг зориулалт бусаар зарцуулах.

*<u>3.3. Өгсөн зөвлөмж:</u>*

Засаг даргын захирамж дахь мөнгөн дүнгээс хэтрүүлэхгүй зарцуулах.

*<u>3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:</u>*

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН

| | |
|---|---|
| ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Д.АНХБАЯР |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | Ж.ЭНХЦООДОЛ |

БЭЛТГЭСЭН:

| | |
|---|---|
| АУДИТОР | Д.ДААРИЙМАА |

Орхон сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР Ж.ЭНХЦООДОЛ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР Д.ДААРИЙМАА

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | | |
|---|---|---|---|
| Огноо: 2020 | Аудитын нэр: | ***Орхон сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит*** | Аудитын код: БУА-2021/135/СТА-ТШ3 |
| Шалгагдсан байгууллагын нэр: | | **Орхон сумын ЗДТГ** | Мянган төгрөгөөр |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Нярвын тайланд 150.0 мянган төгрөгийн бараа материал орлого, зарлагын баримтгүй, 1120.5 мянган төгрөгийн бараа материал шаардахгүй зарцуулсан, 143.0 мянган төгрөгийн засварын хөлс орлогодсон, харилцахын нэхэмжлэх бараа материалын орлого зарлага зөрүүтэй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дэх заалтыг мөрдөж ажиллаагүй байна. | 3270.5 | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дэх заалтыг мөрдөж ажиллах зөвлөмж өгөх. | Тамгын газрын дарга, нягтлан бодогч | Ч.Цагаанхүү Д.Батцэцэг |
| 2 | Нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас цэвэрлэгээний материал худалдан авахаар төлөвлөн зарцуулдаг нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалтыг зөрчсөн байна. | 1000.0 | Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"-ын дагуу төсвийн зардлын төрлийг төлөвлөж зарцуулах зөвлөмж өгөх. | Тамгын газрын дарга, нягтлан бодогч | Ч.Цагаанхүү Д.Батцэцэг |
| 3 | Засаг даргын захирамжаар зарцуулах мөнгөн дүнгээс илүү зарцуулсан нь 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 3.1 дэх заалтыг зөрчсөн байна. | 256.2 | Засаг даргын захирамж дахь мөнгөн дүнгээс хэтрүүлэхгүй зарцуулах зөвлөмж өгөх. | Тамгын газрын дарга, нягтлан бодогч | Ч.Цагаанхүү Д.Батцэцэг |
| 4 | Нэхэмжлэх зарлагын баримтгүй 148.58 мянган төгрөгийг нярвын дансанд шилжүүлсэн. | 148.58 | Нэхэмжлэх зарлагагүй шилжүүлсэн бэлэн мөнгөний зарлагад төлбөрийн акт тогтоох. | Тамгын газрын дарга, нягтлан бодогч | Ч.Цагаанхүү Д.Батцэцэг |
| 5 | Албан томилолтын зардлыг илүү олгосон | 150.0 | Илүү олгосон томилолтын зардалд төлбөрийн акт тогтоох. | Тамгын газрын дарга, нягтлан бодогч | Ч.Цагаанхүү Д.Батцэцэг |
| **ДҮН** | | **4825.6** | | | |